



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Баталсан хууль нь хүн
бүрт тэгш үйлчилдэг
төр л халгийн
тогтвортой оршдог.

Аристотель

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС ЭРХЛЭН ХҮРГЭДЭГ “1800-1202” ПОДКАСТ ДОХИОНЫ ХЭЛМЭРЧТЭЙГЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРЧ ЭХЭЛЛЭЭ



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 подкаст



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ИРГЭН ТАНД ХУУЛЬ ЗҮЙН
ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЭЛ ХЭРЭГТЭЙ
БАЙНА УУ?

ИРГЭН ТА



1800-1202

ТУСАЙ ДУГААРЫН УТСАНД
ХОЛБОГДОЖ, ХУУЛЬ ЗҮЙН
АНХАН ШАТНЫ ЗӨВЛӨГӨӨ,
МЭДЭЭЛЭЛ АВААРАЙ.



БНСУ-ЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЯАМНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД АЙЛЧИЛЛАА

Хууль зүйн үндэсний зүйн үндэсний хүрээлэн эдийн засгийн тогтолцоог хүрээлэнгийн захирал дээр хүлээн авч уулзлаа. бэхжүүлэхтэй холбоотой Х.Эрдэм-Ундрах (Dr. Уулзалтаар Монгол Улсын өмгөөлөгч, төрийн албан jur.) БНСУ-ын Хууль эдийн засгийн тогтолцооны хаагч, иргэдийн боловсролыг тогтоомжийн яамны Эрх өөрчлөлттэй холбоотой эрх сайжруулах зорилготой зүйн харилцаа, хамтын зүйн шинэчлэлийн үйл явц, сургалтын талаар мэдээлэл ажиллагааны хэлтсийн дэд хөрөнгө оруулалтын эрх хүргэв. Түүнчлэн Хууль дарга И Ил, үйл ажиллагаа зүйн орчныг сайжруулахтай тогтоомжийн яамтай хамтын хариуцсан мэргэжилтэн Сун холбоотой авч хэрэгжүүлж ажиллагааг эрчимжүүлэх Сэн Хуан, судлаач Хуан Хён буй арга хэмжээ, Чөлөөт чиглэлээр санал солилцлоо. Үг нарыг 2023 оны 08 дугаар бүсийн тухай хуулийн сарын 18-ны өдөр Хууль хэрэгжилт болон чөлөөт



ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ
ТУХАЙ ХУУЛЬ

ЭНЭ ХУУЛИЙН ЗОРИЛТ НЬ ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, АШИГЛАХ,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХАД ОРШИНО.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛД:

- ✓ ХҮНИЙ ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ
- ✓ ХҮНИЙ ЭЦЭГ /ЭХ/-ИЙН НЭР, ӨӨРИЙН НЭР
- ✓ ТӨРСӨН ОН, САР, ӨДӨР
- ✓ ТӨРСӨН ГАЗАР, ОРШИН СУУГАА ГАЗРЫН ХАЯГ, БАЙРШИЛ
- ✓ ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ДУГААР
- ✓ ХӨРӨНГӨ
- ✓ БОЛОВСРОЛ
- ✓ ГИШҮҮНЧЛЭЛ
- ✓ ЦАХИМ ТОДОРХОЙЛОГЧ
- ✓ ХҮНИЙГ ШУУД БОЛОН ШУУД БУСААР ТОДОРХОЙЛОХ, ЭСХҮЛ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖТОЙ БУСАД МЭДЭЭЛЛИЙГ



ХҮНИЙ ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛД:

- ✓ ҮНДЭС, УГСАА
- ✓ ШАШИН ШҮТЛЭГ
- ✓ ИТГЭЛ ҮНЭМШИЛ
- ✓ ЭРҮҮЛ МЭНД
- ✓ ЗАХИДАЛ ХАРИЛЦАА
- ✓ ГЕНЕТИК БОЛОН БИОМЕТРИК МЭДЭЭЛЭЛ
- ✓ ТООН ГАРЫН ҮСГИЙН ХУВИЙН ТҮЛХҮҮР
- ✓ ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА БОЛОН ЯЛ ЭДЭЛСЭН ЭСЭХ
- ✓ БЭЛГИЙН БОЛОН ХҮЙСИЙН ЧИГ БАРИМЖАА
- ✓ БЭЛГИЙН ХАРЬЦАА

Иргэн танд хууль зүйн зөвлөгөө,
мэдээллийг энгийн утасны тарифаар
хүргэх утас:

1800-1202



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС ЭРХЛЭН ХҮРГЭДЭГ “1800-1202” ПОДКАСТ ДОХИОНЫ ХЭЛМЭРЧТЭЙГЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРЧ ЭХЭЛЛЭЭ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн хүргэдэг “1800-1202” подкаст дохионы хэлмэрчтэйгээр олон нийтэд хүрч эхэллээ. Тус подкаст 2021 оны 02 сарын 08-ны өдрөөс гарч эхэлснээс хойш нийт 106 дугаар олон нийтэд хүрсэн байна.

“1800-1202” подкастыг “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх

үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор бэлтгэн хүргэж байна. Подкастад Хууль зүй, дотоод хэргийн яам, Соёлын яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Дотоод хэргийн их

сургууль, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Цагдаагийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Монгол улсын их сургууль зэрэг байгууллагуудаас гадна хуулийн фирмийн өмгөөлөгч, хуульчид зочноор оролцсон байна.



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС ЭРХЛЭН ХҮРГЭДЭГ “1800-1202” ПОДКАСТЫН 2023 ОНЫ БҮХ ДУГААР ДОХИОНЫ ХЭЛМЭРЧТЭЙГЭЭР ФЭЙСБҮҮК БОЛОН Ю-ТҮҮБ ХУУДСАНД НИЙТЛЭГДЛЭЭ.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr. jur) Европын Холбооны Ижилсүүлэх төслийн зөвлөх Эммануэл Вэрн болон Европын Холбооны Монгол дахь Төлөөлөгчийн газрын төлөөлөгчдийг 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч, зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа.

Зөвлөлдөх уулзалтын хүрээнд хууль зүйн салбар дахь өнөөгийн нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох,

мөн Европын Холбооны Төлөөлөгчийн газраас 2021-2027 оны хооронд Монгол Улсад хэрэгжүүлэх Олон жилийн баримжаат хөтөлбөрийн хүрээнд хууль зүйн салбарын шинэчлэлтэй холбогдуулан 2024 оноос хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх Ижилсүүлэх (Twinning) төслийн талаар харилцан мэдээлэл солилцов. Ижилсүүлэх (Twinning) төсөл нь шүүхийн шинэчлэл, шүүх засаглалыг үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан

сайжруулах зорилгын хүрээнд хэрэгжих юм.

Тус уулзалтаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн чиг үүрэг, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаатай танилцсан бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхэд Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран оролцох, цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар санал солилцлоо.



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН WWW.NLI.GOV.MN ЦАХИМ ХУУДАСНЫ “ЦАХИМ НОМЫН САН” ЦЭСЭНД ТУС ХҮЛЭЭЛЭНГЭЭС ЭРХЛЭН ГАРГАДАГ “ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛИЙН 2003 ОНЫ АНХНЫ ДУГААРААС ЭХЛЭН НИЙТЛЭГДЭЖ ЭХЭЛЛЭЭ.

УНШИГЧ ТА “ЦАХИМ НОМЫН САН” ЦЭСЭНД ХАНДСАНААР ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС СЭТГҮҮЛЭЭС ГАДНА, СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН БОЛОН ИТГЭЛИЙН ЭМХЭТГЭЛҮҮДИЙГ ЦАХИМААР УНШИХ БОЛОМЖТОЙ.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

ЭЭЛЖИЙН АМРАЛТ ЭДЛЭХ ЭРХ ХЭРХЭН ҮҮСЭХ ВЭ?

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/Та дараах тохиолдолд **ЭЭЛЖИЙН АМРАЛТ** эдлэх эрхтэй.Ажилтанд ажлын **ЖИЛ БҮР**
ээлжийн амралт олгож биеэр
эдлүүлнэ.

1

Хөдөлмөрийн гэрээ байгуулснаас
хойш **6 САР АЖИЛЛАСАН.**

2

**ТУРШИЛТААР БОЛОН
ДАГАЛДАНГААР** ажиллах
хөдөлмөрийн гэрээ байгуулснаас
хойш **6 САР ӨНГӨРСӨН.**

3

Зэрэгцэн хөдөлмөрийн гэрээ
байгуулж ажилладаг бол үндсэн
ажил олгогчоосоо **ЭЭЛЖИЙН
АМРАЛТ АВАХ ЭРХТЭЙ.**

4

Ээлжийн амралтын эрх
нээгдсэнээс хойш ажлаас гарсан
тохиолдолд **ЭЭЛЖИЙН
АМРАЛТЫН МӨНГИЙГ ШААРДАХ
ЭРХТЭЙ.**

5

Ажлын зайлшгүй шаардлагаар
ээлжийн амралтаа биеэр аваагүй
бол ээлжийн амралтын цалинг
**1.5 ДАХИН НЭМЭГДҮҮЛЖ АВАХ
ЭРХТЭЙ.**

6

**ЭЭЛЖИЙН АМРАЛТ:** АЖИЛТАНД ЖИЛ БҮР БИЕЭР БОЛОН ХУУЛЬД ЗААСНААР МӨНГӨН
УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГЭЭР ОЛГОХ АМРАЛТЫГ ХЭЛНЭ.



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд ажилласан жилээс хамааран дараах байдлаар **НЭМЭГДЭЛ АМРАЛТ ОЛГОНО.**

6-10 ДАХЬ
ЖИЛД

5
өдөр

11-15 ДАХЬ
ЖИЛД

7
өдөр

16-20 ДАХЬ
ЖИЛД

9
өдөр

21-25 ДАХЬ
ЖИЛД

12
өдөр

26-31 ДАХЬ
ЖИЛД

15
өдөр

32 ДАХЬ
ЖИЛЭЭС

18
өдөр



1800-1202
Хууль зүйн зөвлөгөө,
мэдээллийг энгийн утасны
тарифаар

ХУУЛЬЧДЫН НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААРХ НОМООР АРВИЖЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэдэх Хуульчдын номын сан нь эрдэмтэн судлаач, бодлого боловсруулагч, эрх зүйн чиглэлээр суралцаж буй оюутан түүнчлэн нийт иргэдэд хууль, эрх зүйн чиглэлээр мэдлэг, боловсрол олгох, тэднийг хөгжүүлэх судалгааны түшиц номын сан юм.

Тиймээс Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын албанаас Бүх нийтийн жендэрийн боловсролыг дэмжих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай

хууль болон төрөөс барьж буй бодлого шийдвэрийн хэрэгжилтийг олон нийтэд хүргэх зорилгоор олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх хүрээнд хэвлүүлсэн бүтээлүүдийн дээжийг Хуульчдын номын сангийн сан хөмрөгт хадгалууллаа.

Жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэг олгох олон талт бүтээлүүдийг Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр 2023 оны 08 дугаар сарын 29-

ний өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн төлөөллүүдэд хүлээлгэн өглөө. Тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор М.Түвшинжаргал, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, доктор Э.Саранцэцэг, Номын сангийн менежер Х.Ариунсүрэн нар жендэрийн талаарх мэдлэг түгээх номоор Хуульчдын номын сангийн сан хөмрөгийг арвижуулсанд талархаж буйгаа илэрхийлэв.

Уншигч та бүхэн Хуульчдын номын сангаас дараах бүтээлүүдийг унших боломжтой боллоо.

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/
2. Жендэрийн нэр томьёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын товч тайлбар толь
3. Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого
4. Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлс суурь судалгааны тайлан
5. Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ
6. Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж
7. “Санхүү, бизнесийн боловсрол” гарын авлага
8. Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргазүйн зөвлөмж.

